



МОНГОЛ УЛСЫН  
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН  
ТУШААЛ

2020 оны 09 сарын 06 өдөр

Дугаар 2/421

Улаанбаатар хот

Коронавируст халдвар (КОВИД-19) болон  
эмнэлгийн тусламж үйлчилгээнд нэн  
шаардлагатай эмэнд импортын  
лиценз олгох тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.5 дахь хэсэг, Засгийн газрын 2020 оны 7 дугаар сарын 29-ний өдрийн “Бэлэн байдлын зэрэгт шилжүүлэх хугацааг сунгах тухай” 31 дүгээр, 8 дугаар сарын 25-ны өдрийн “Бэлэн байдлын зэрэгт шилжүүлэх хугацааг сунгах тухай” 70 дугаар тогтоолын 1 дэх заалт, Хүний эмийн зөвлөлийн 2020 оны 7 дугаар сарын 08-ны өдрийн 9 дүгээр, 2020 оны 8 дугаар сарын 19-ний өдрийн 10 дугаар хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Ази фарма ХХК-д импортын лиценз олгох эмийн жагсаалтыг нэгдүгээр, Омбол ХХК-д импортын лиценз олгох эмийн жагсаалтыг хоёрдугаар, Интернэйшнл Медикал Сентер ХХК-д импортын лиценз олгох эмийн жагсаалтыг гуравдугаар хавсралтаар тус тус баталсугай.
2. Бодлогоор бүртгэх эмийн бүртгэлийн үйл ажиллагааг эрчимжүүлж ажиллахыг Эрүүл мэндийн хөгжлийн төв /Б.Нарантуяа/-д даалгасугай.
3. Импортолсон эмийн чанар, аюулгүй байдлыг бүрэн хариуцаж, импортлох үйл ажиллагааг шуурхай зохион байгуулж ажиллах, эмийн сан, эрүүл мэндийн байгууллагыг эмээр тасралтгүй, жигд хангаж, зохиомол хомсдол, үнийн хөөрөгдөл үүсгэхгүй байхыг эм ханган нийлүүлэх байгууллагуудын дарга, захирал нарт үүрэг болгосугай.
4. “Ремдесивир” эмийг холбогдох заавар, журмын дагуу эмчилгээнд хэрэглэхэд хяналт тавьж ажиллахыг Эмнэлгийн тусламжийн газар /Я.Буянжаргал/-д, Эм, үйлдвэрлэл, технологийн газар /Н.Гэрэлт-Од/-д тус тус үүрэг болгосугай.
5. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн нарийн бичгийн дарга /Я.Амаржаргал/-д даалгасугай.

САЙД



Т.МӨНХСАЙХАН

Эрүүл мэндийн сайдын  
2020 оны 08 сарын 06 өдрийн 4/ тушаалын  
нэгдүгээр хавсралт 4067

Ази фарма ХХК-д импортын лиценз олгох  
эмийн жагсаалт

№	Эмийн нэр	Тун хэмжээ	Эмийн хэлбэр	Импортлох тоо хэмжээ	Үйлдвэрлэгчийн нэр, улс
1.	Мегабета /Бетагистин/	24мг №30	шахмал	5000	Huons, БНСУ

Эрүүл-мэндийн сайдын  
2020 оны 09 сарын 02 өдрийн 4/ тушаалын  
хоёрдугаар хавсралт 427



Омбол ХХК-д импортын лиценз олгох  
эмийн жагсаалт

№	Эмийн нэр	Тун хэмжээ	Эмийн хэлбэр	Импортлох тоо хэмжээ	Үйлдвэрлэгчийн нэр, улс
1.	Ципрема (Ремдесивир)	100мг	Лиофилжүүлсэн тарилгын нунтаг	600 флакон	Cipla, БНЭУ

Эрүүл мэндийн сайдын  
2020 оны 09 сарын 02 өдрийн 4/ тушаалын  
гуравдугаар хавсралт

Интернэйшнл Медикал Сентер ХХК-д  
импортын лиценз олгох эмийн жагсаалт

№	Эмийн нэр	Тун хэмжээ	Эмийн хэлбэр	Импортлох тоо хэмжээ	Үйлдвэрлэгчийн нэр, улс
1.	Геммис (Гемцитабин)	200мг (38мг/мл, 6мл)	Тарилгын уусмал	207	TTY Biopharm Company Limited, Тайван
2.	Иннокан (Иринотекан гидрохлорид тригидрат)	100мг/5мл	Тарилгын уусмал	432	Yungshin Pharm Ind.Co.,Ltd, Тайван
3.	Фолина (Леуковорин кальциум, Ангидрат)	100мг/10мл	Тарилгын уусмал	4365	TTY Biopharm Company Limited, Тайван
4.	Оксалип (Оксалиплатин)	100мг/20мл	Тарилгын уусмал	234	TTY Biopharm Company Limited, Тайван